

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УТХО - УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ОНТ – ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

АЗДТГ – АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТЗУХ – ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

ХЭЗХ – ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

НБХ – НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ХОХБТХ – ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

СТСХ – САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

ААН – АЖ АХУЙН НЭГЖ

ЦГ- ЦАГДААГИЙН ГАЗАР

БСУГ- БОЛОВСРОЛ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

НД – НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

ХХҮҮГ- ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ХХААГ- ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

БОАЖГ- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ЭМГ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ОБГ- ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

ГХБХБГ- ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

ГБХЗХГ- ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

МЭГ- МАЛ ЭМНЭЛЭГИЙН ГАЗАР

ШША – ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

УЦУОШТ – УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

СУБ – СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГА

ТХДЖТ – ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖҮЖГИЙН ТЕАТР

ТТХТ – ТЭНГЭРИЙН ТЭМДЭГ ХҮҮХДИЙН ТЕАТР

МСҮТ – МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

БТСГ – БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ГХУСАЗЗ–ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ

ОНӨҮГ – ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

БЗӨБЦТС - БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ

ТӨХК – ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЦТСС – ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ САЛБАР

ШҮГ – ШУУДАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ОУБ – ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

ЭТИС - ЭРДЭС БАЯЛАГ ТҮҮХИЙ ЭДИЙН ИЖ БҮРЭН САНААЧЛАГА

ЭМДТ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

ЦШ-ЦЭРГИЙН ШТАБ

ДУНДГОВЬ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Зорилго 1. Аймгийн ДНБ-д соёл урлагийн салбарын эзлэх хувь 2019 онд 0.61 хувь байсныг 2025 онд 0.81 хувьд хүргэнэ.

Үндэсний бахархал, эв нэгдэл

Зорилго 1.1 Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэд 2019 онд 294454 байгааг 2025 онд 46400-аар нэмэгдүүлнэ.

Зорилт 1.1.1 2020 онд соёл урлагийн салбарт насжилт өндөртэй барилга байгууламж 14 байгааг 2025 онд 85,7 хувийг нь шинэчилж, чанартай тоног төхөөрөмжөөр хангана.

1.1.1.1 Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулна.

1.1.1.2 Аймгийн Музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

1.1.1.3 Хүүхдийн театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулна.

1.1.1.4 Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.

1.1.1.5 Аймгийн Төв Номын сангийн барилгын дээврийн засвар, Сайхан-Овоо сумын Соёлын төвийн барилгад их засвар хийнэ.

Зорилт 1.1.2 Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 60 байгааг 2025 онд 78.8 хувьд хүргэнэ.

1.1.2.1 Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, орон тоог нэмэгдүүлэн, салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.2.2 Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг орон сууцжуулна.

Зорилт 1.1.3 Монгол зан заншил, өв соёлоо дээдэлсэн эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээнд хамрагдагсадыг 2020 онд 986 байгааг 2025 онд 6500-д хүргэнэ.

1.1.3.1 Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээт хамгаалагчтай болгоно.

1.1.3.2 "Бүрдийн уянга" хүүхдийн зусланг түшиглэн "Ардын зан үйл-амьдрах арга ухаан" хөтөлбөрт сургалтыг зохион байгуулна.

1.1.3.3 Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх "Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч" төслийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулна.

Нүүдлийн соёл иргэншилт Монгол

Зорилго 1.2 Нүүдлийн өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх соёл урлагийн арга хэмжээ 2019 онд 1431 байсныг 2025 онд 2876-д хүргэнэ.

Зорилт 1.2.1 Монгол үндэсний өв соёлыг орон нутгийнхаа онцлогт нийцүүлэн туурвисан шинэ уран бүтээл 2020 онд 7 байсныг 2025 онд 2 дахин нэмэгдүүлнэ.

1.2.1.1 Аймгийн Засаг даргын дэргэд "Мэргэжлийн соёл, урлагийн зөвлөл" байгуулан, соёл, урлагийн салбарын бодлого, үйл ажиллагааг чиглүүлнэ.

1.2.1.2 "Уяхан замбуу тивийн наран" уртын дуучид, морин хуурчдын эвент наадмыг зохион байгуулна.

1.2.1.3 Музейн сан хөмрөгийг насжилт өндөртэй эртний үзмэрүүдээр баяжуулан, нүүдлийн өв соёлыг сурталчилна.

1.2.1.4 Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулна.

1.2.1.5 Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан түүхэн баримтат кино хийнэ.

1.2.1.6 Аймгийн гар урчуудын бүтээлээр үзэсгэлэн-худалдаа зохион байгуулж, дэг сургууль, арга барилыг нь өвлүүлнэ.

Монгол бичиг

Зорилго 1.3 Дүндговьчуудын Үндэсний монгол хэл, бичгийн боловсрол эзэмшсэн байдал 2020 оны байдлаар 4782 байгааг 2025 онд 6692 -д хүргэж, хос бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

Зорилт 1.3.1 Төрийн албан хаагчдын Монгол бичгийн хэрэглээг 2020 онд 10 хувьтай байгааг 2025 онд 100 хувьд хүргэнэ.

1.3.1.1 Албан байгууллага, аж ахуй нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, нэрийн хуудас, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлнэ

1.3.1.2 Төрийн албан хаагчдын модуль сургалтын кредитийг тооцон урамшуулал олгоно

1.3.1.3 "Улсын монгол бичгийн олимпиад"-ыг аймагт зохион байгуулна

1.3.1.4 "Үндэсний бичиг " олон талт арга хэмжээг зохион байгуулна